

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

Үүргийн биелэлтийг Arial-11 фонтоор бичиж, **2025 оны 03 дугаар сарын 18-ны “Мягмар” гаргт** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн (ЕРП Б.Одбаяр)-д албан бичгээр болон word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд онцгой анхаарч биелэлтийг ирүүлэхдээ нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 8.6 дахь хэсэгт заасан дараах шаардлагын дагуу тайлагнахыг анхаарна уу

8.6.Байгууллагаас ирүүлэх бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, холбогдох тайлан, мэдээ нь дараах шаардлагыг хангасан байна:

8.6.1. үйл ажиллагааны гүйцэтгэлийг бүрэн багтаасан, тайлант хугацааг бүрэн хамруулсан байх.

8.6.2. үг үсгийн болон хэл найруулгын хувьд алдаагүй, тоо баримт зөрөөгүй байх;

8.6.5. тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгасан байх;

8.6.6. хийсэн ажлыг бүрэн хамруулж, үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийн үндэслэл, шалтгааныг тодорхой гаргасан байх;

8.6.7. хэрэгжилтийг 2000 (хоёр мянган) тэмдэгтэд багтааж, үр дүн, үр нөлөөг тайлагнах

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Гэрээний үүргээ биелүүлээгүй тендерт оролцогч компаниудыг хар жагсаалтад оруулах нэрсийг гаргаж танилцуулах.	СТСХ
2	Үлдэгдэл давс, бодисыг зориулалтын битүү дээвэртэй, стандартын шаардлага хангасан байранд нөөцөлж хадгалах ажлыг зохион байгуулах.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
3	Инженерийн шугам, сүлжээний засвар, шинэчлэлийн талаар дараагийн Шуурхай зөвлөгөөн дээр танилцуулах чиглэл өгөгдсөний дагуу холбогдох мэдээллийг бэлтгэн хүргүүлэх.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Инженерийн хангамжийн байгууллагууд
4	Хөрөнгө оруулалтаар шинэчилсэн хот нийтийн аж ахуйн машин тоног төхөөрөмжийн ашиглалтын асуудлаар санал, гомдлоо нэгтгэн УБЗАА-нд хүргүүлэх.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
5	Дүүргийн нутаг дэвсгэрт 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэгдэх зам засварын ажлын тендерийг зарлаж, ажлыг эрчимжүүлэх.	ХААА, Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ
6	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн 440,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэгдэх ажлыг эрчимжүүлэх, гүйцэтгэлд онцгой анхаарах.	ХААА, Захиалагчийн хяналт тавих байгууллагууд
7	Орчны аюулгүй байдлыг хангуулах үзлэг шалгалтыг зохион байгуулан, цэвэрлэгээний ажлыг гүйцэтгэх.	ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, нийт байгууллагууд
8	Салхи шуурга, хаврын хуурайшлын үеийн	ОБХ

	аюулаас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэн, аюулгүй байдлыг хангуулах.	
9	2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр нийслэлийн төсөвт тодотгол хийгдэхтэй холбогдуулан холбогдох мэдээллийг бэлтгэн танилцуулах.	СТСХ

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР